



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/189/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
https://audit.mn/?page_id=579
Мөрөн хот

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ихэрмөрөн-аудит ХХК-ийн
Захирал: Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Чанарын хяналтын менежер: Д.Оюундаваа
Утас: 96199692 Цахим хаяг: oyundavaa9692@gmail.com
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.24 № 01/127
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГА Ч.ДАШБАЯР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,666,235.80	42,683,394.80
33	АВЛАГА	12,407,806.00	1,829,703.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	860,812.00	860,812.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,578,103.00	00.00
335	Бусад авлага	968,891.00	968,891.00
3351	Байгууллагаас авах авлага	968,891.00	968,891.00
35	БАРАА МАТЕРИАЛ	40,258,429.80	40,853,691.80
351	Түүхий эд материал	00.00	155,321.80
35130	Эм боох материал	00.00	155,321.80
354	Хангамжийн материал	40,258,429.80	40,698,370.00
35420	Аж ахуйн материал	24,706,133.00	22,190,633.00
35470	Бусад хангамжийн материал	15,552,296.80	18,507,737.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,299,137,626.39	2,320,459,494.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,299,137,626.39	2,320,459,494.70
392	Биет хөрөнгө	2,236,381,626.39	2,257,428,494.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,271,808,260.00	2,271,808,260.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-75,857,620.80	-113,786,431.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	25,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-8,333,333.28	-12,499,999.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	96,956,097.37	112,263,653.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	-86,044,776.97	-33,064,715.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,321,638.00	56,745,446.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,068,519.93	-49,037,718.28
39217	Ном	599,882.00	00.00
393	Биет бус хөрөнгө	62,756,000.00	63,031,000.00
39301	Програм хангамж	686,000.00	961,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	62,620,000.00	62,620,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,351,803,862.19	2,363,142,889.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,921,346.00	6,173,659.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,921,346.00	6,173,659.96
413	Өглөг	8,921,346.00	6,173,659.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	392,567.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	8,528,779.00	6,173,659.96
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,342,882,516.19	2,356,969,229.54
51	Засгийн газрын хувь оролцоо	2,342,882,516.19	2,356,969,229.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,629,021.00	130,629,021.00
51101	Өмч: - төрийн	130,629,021.00	130,629,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,002,265,795.88	1,016,352,509.23
51210	Өмнөх үеийн үр дүн	1,002,265,795.88	1,002,265,795.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	14,086,713.35
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,209,987,699.31	1,209,987,699.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,351,803,862.19	2,363,142,889.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	560,503,205.00	620,735,922.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,035,605.00	82,263,522.20
120	Нийтлэг татварын бус орлого	14,035,605.00	82,263,522.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,035,605.00	82,263,522.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,240,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,795,605.00	82,263,522.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	546,467,600.00	538,472,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	315,896,200.00	296,519,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,223,000.00	90,460,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000,000.00	00.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,263,000.00	78,650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,960,000.00	11,810,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,348,400.00	151,493,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,348,400.00	151,493,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	600,741,236.50	604,921,208.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600,741,236.50	604,921,208.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,969,119.47	598,422,027.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,571,442.00	144,358,118.00
210101	Үндсэн цалин	180,755,142.03	115,636,620.70
210102	Нэмэгдэл	28,816,299.97	28,721,497.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,196,431.99	18,577,076.08
210201	Тэтгэврийн даатгал	17,813,573.99	12,867,419.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,095,714.00	1,427,415.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,676,572.00	1,141,932.08
210204	Ажилгүйдлийн даатгал	419,143.00	285,483.07
210205	Эрүүл мэндийн даатгал	4,191,429.00	2,854,825.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,946,190.00	153,539,101.06
210301	Гэрэл, цахилгаан	4,369,329.00	4,855,521.00
210302	Түлш, халаалт	143,171,179.00	143,171,180.96
210303	Цэвэр, бохир ус	4,405,682.00	5,512,399.10
2104	Хангамж, бараа материалын зардал	11,289,273.20	9,348,694.00
210401	Бичиг хэрэг	2,876,900.00	3,422,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,420.00	3,313,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,848,500.00	1,393,864.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,500.00	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,416,953.20	1,153,100.00
2105	Нормативт зардал	3,071,967.00	4,860,000.00
210502	Хоол, хүнс	3,071,967.00	4,860,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,250,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,250,000.00
2107	Томилолт, зочны зардал	72,000.00	1,429,400.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	1,429,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,435,124.98	199,163,146.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,196,300.98	197,793,959.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	33,000.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	55,962.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	471,500.00	399,000.00
210807	Газрын төлбөр	234,824.00	319,825.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,386,690.30	62,168,491.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,829,400.00	3,468,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,557,290.30	58,700,491.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,772,117.03	8,227,181.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,515,988.00	1,178,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,715,988.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,178,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,377,902.00	63,793.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,377,902.00	4,447.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	59,346.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,878,227.03	6,985,187.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,878,227.03	6,985,187.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-40,238,031.50	15,814,713.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	1,728,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,728,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-1,728,000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-40,238,031.50	14,086,713.35

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,042,503,827.38	2,383,120,547.69
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,042,503,827.38	2,383,120,547.69
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-40,238,031.50	-40,238,031.50
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,002,265,795.88	2,342,882,516.19
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,002,265,795.88	2,342,882,516.19
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	14,086,713.35	14,086,713.35
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,629,021.00	1,209,987,699.31	1,016,352,509.23	2,356,969,229.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	555,707,600.00	549,050,503.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,240,000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,240,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,240,000.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,240,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	546,467,600.00	549,050,503.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	315,896,200.00	296,519,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	87,223,000.00	101,038,103.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,263,000.00	89,228,103.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,960,000.00	11,810,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	143,348,400.00	151,493,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	143,348,400.00	151,493,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	552,607,600.00	548,775,503.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552,607,600.00	548,775,503.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,257,379.97	540,548,321.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	147,483,599.97	144,358,118.00
210101	Үндсэн цалин	118,667,300.00	115,636,620.70
210102	Нэмэгдэл	28,816,299.97	28,721,497.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,910,300.00	18,577,076.08
210201	Тэтгэврийн даатгал	14,010,900.00	12,867,419.90
210202	Тэтгэмжийн даатгал	1,474,800.00	1,427,415.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,179,900.00	1,141,932.08
210204	Ажилгүйдлийн даатгал	295,000.00	285,483.07
210205	Эрүүл мэндийн даатгал	2,949,700.00	2,854,825.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	143,417,411.00	155,894,220.10
210301	Гэрэл, цахилгаан	4,369,329.00	4,855,521.00
210302	Түлш, халаалт	134,642,400.00	145,526,300.00
210303	Цэвэр, бохир ус	4,405,682.00	5,512,399.10
2104	Хангамж, бараа материалын зардал	14,569,170.00	10,815,764.00
210401	Бичиг хэрэг	2,876,900.00	3,422,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,999,420.00	3,313,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,848,500.00	1,393,864.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,500.00	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,696,850.00	2,620,170.00
2105	Нормативт зардал	3,071,967.00	00.00
210502	Хоол, хүнс	3,071,967.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	750,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	750,000.00

2107	Томилолт, зочны зардал	72,000.00	1,429,400.00
210702	Дотоод албан томилолт	72,000.00	1,429,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,903,532.00	199,555,743.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	149,664,708.00	198,186,556.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	33,000.00	54,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	55,962.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	471,500.00	399,000.00
210807	Газрын төлбөр	234,824.00	319,825.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,829,400.00	9,168,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,829,400.00	9,168,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,350,220.03	8,227,181.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,515,988.00	1,178,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,715,988.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	1,178,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,956,005.00	63,793.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,956,005.00	4,447.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		59346.90
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,878,227.03	6,985,187.92
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,878,227.03	6,985,187.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,100,000.00	275,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,100,000.00	275,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,100,000.00	275,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,100,000.00	275,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,100,000.00	275,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,100,000.00	-275,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	448,012,400.00	441,022,765.08	6,989,634.92	98.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	448,012,400.00	441,022,765.08	6,989,634.92	98.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,748,300.00	439,844,565.08	6,903,734.92	98.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	144,583,500.00	144,358,118.00	225,382.00	99.84
210101	Үндсэн цалин	115,767,300.00	115,636,620.70	130,679.30	99.89
210102	Нэмэгдэл	28,816,200.00	28,721,497.30	94,702.70	99.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,910,300.00	18,577,076.08	1,333,223.92	93.30
210201	Тэтгэврийн даатгал	14,010,900.00	12,867,419.90	1,143,480.10	91.84
210202	Тэтгэмжийн даатгал	1,474,800.00	1,427,415.15	47,384.85	96.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,179,900.00	1,141,932.08	37,967.92	96.78
210204	Ажилгүйдлийн даатгал	295,000.00	285,483.07	9,516.93	96.77
210205	Эрүүл мэндийн даатгал	2,949,700.00	2,854,825.88	94,874.12	96.78
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151,493,000.00	151,488,553.00	4,447.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	4,809,900.00	4,805,453.00	4,447.00	99.91
210302	Түлш, халаалт	143,170,700.00	143,170,700.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,512,400.00	3,512,400.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,927,600.00	5,334,794.00	592,806.00	90.00
210401	Бичиг хэрэг	1,427,600.00	1,427,600.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	3,000,000.00	2,998,730.00	1,270.00	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,500,000.00	908,464.00	591,536.00	60.56
2107	Томилолт, зочны зардал	1,440,000.00	1,429,400.00	10,600.00	99.26

210702	Дотоод албан томилолт	1,440,000.00	1,429,400.00	10,600.00	99.26
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж				
		120,044,400.00	115,308,624.00	4,735,776.00	96.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,552,100.00	113,828,437.00	4,723,663.00	96.02
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	450,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	54,400.00	54,400.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,000.00	55,962.00	12,038.00	82.30
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	600,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	319,900.00	319,825.00	75.00	99.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
		3349500.00	3348000.00	1,500.00	99.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,349,500.00	3,348,000.00	1,500.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
		1264100.00	1178200.00	85,900.00	93.20
2132	Бусад урсгал шилжүүлэг				
		1,264,100.00	1,178,200.00	85,900.00	93.20
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,264,100.00	1,178,200.00	85,900.00	93.20
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР				
		448,012,400.00	441,022,765.08	6,989,634.92	98.44
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		296,519,400.00	289,534,212.08	6,985,187.92	97.64
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	296,519,400.00	289,534,212.08	6,985,187.92	97.64
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
		151,493,000.00	151,488,553.00	4,447.00	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	151,493,000.00	151,488,553.00	4,447.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	101,038,103.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	101,038,103.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	100,978,756.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,405,667.10
210301	Гэрэл, цахилгаан	50,068.00
210302	Түлш, халаалт	2,355,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,999,999.10
2104	Хангамж, бараа материалын зардал	5,480,970.00
210401	Бичиг хэрэг	1,994,800.00
210402	Тээвэр, шатахуун	314,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	485,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,620,170.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00
210604	Урсгал засвар	750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,522,119.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	84,358,119.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	74,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5820000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,820,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,346.90
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	59,346.90
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	101038103.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,038,103.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89,228,103.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,810,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зохицуулалт, он дамжсан авлага, өр төлбөрийг барагдуулах, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн аудитор Ц.Мөнхтуяа гүйцэтгэж, хяналтыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа хийж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатны хяналтыг, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн хөгжих, оролцох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харьяа байгууллага юм. Ковид-19 коронавирусын халдварын улмаас 2021 онд сургууль, цэцэрлэг бүрэн ажиллаагүй, хүүхдүүд гэрээр ихэвчлэн байсан тул иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, аливаа хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, иргэдэд шаардлагатай мэдлэг мэдээлэл хүргэх, нийгмийг сайн сайхан, эерэг хандлагад уриалах, сайн туршлага, үлгэр дуурайлыг алдаршуулан түгээх болон хүүхэд хамгааллын чиглэлд гол анхаарлаа хандуулж ажилласан.

Байгууллагын дээрх зорилтын хүрээнд 2021 онд хэрэгжүүлсэн ажлуудаас товч дурьдвал:

- Аймаг, сумдын Хүүхдийн төлөө зөвлөлийг чадавхжуулахад чиглэсэн сургалт, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлыг сумдад үе шаттай зохион байгуулсан.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээг 2021 онд 162 хүүхэд үзүүлснээс гэрч 36, хохирогч 55, гэмт хэрэгт холбогдсон 26 хүүхэд байна. Гэмт хэрэгт холбогдсон болон гэрч, хохирогч нийт хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгчөөр 31 удаа ажиллаж, үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээг 14 удаа үзүүлсэн.
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн зардалд орон нутгийн төсвөөс 60 сая төгрөгийн санхүүжилт олгосноор 7 албан хаагч, 517 хүнд, 1129 удаагийн үйлчилгээг үзүүлсэн.

- Төвийн үйлчилгээ авч, гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн иргэдийг хамтарсан багт нь хүлээлгэн өгч, гэр эргэлт хийх ажилд 22 өрхийн насанд хүрсэн 37 иргэн, 65 хүүхдийг хамруулж, тухайн өрхүүдэд хүнсний дэмжлэг үзүүлсэн.
- Байгууллагын дэргэдэх Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг гэрээгээр ажиллуулж, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээг 889 иргэнд хүргэсэн. 3 суманд мэргэжлийн сэтгэл зүйчдийн явуулын үйлчилгээг зохион байгуулж, зорилтот 160 өрхийн 460 орчим иргэн, ахлах ангийн 130 сурагчдад зөвлөгөө өгч, сургалтад хамруулсан.
 - Аймгийн хэмжээнд 24 сумын 38 хамтарсан багийн 304 гишүүн гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг хэрэгжүүлж байна. 2021 онд 3428 урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 931470 насанд хүрэгчийг хамруулсан байна. Хариу үйлчилгээний хүрээнд 316 удаагийн нөхцөл байдлын үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, гэр бүлд нь эргэн нэгтгэх, сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, дэмжин холбон зуучлах үйлчилгээнүүдийг 3485 хүүхэд, 5152 насанд хүрэгч, 1309 гэр бүлд үзүүлсэн байна. Мөн хүүхэд хамгааллын үйлчилгээг 335 хүүхэдэд үзүүлсэн байна.
 - Аймгийн залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, залуучуудын асуудлаарх салбар дундын бодлого, зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна.
 - Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүлээж авсан дуудлагыг бүрэн шийдвэрлэх зорилт тавин ажиллаж, 74 дуудлагыг бүрэн шийдвэрлэсэн, 87 дуудлагыг хяналтад авсан байна.
 - “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-ээр дамжуулан 1000 гаруй багш, ажилчид, 35 хүүхэд хамгааллын баг, 921 сурагчид, 225 эцэг эх, асран хамгаалагчдад гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.
 - Орон нутгийн хэвлэл мэдээллийн 5 байгууллагатай хамтран ажиллаж, хүүхэд хамгааллын чиглэлээр 10 зөвлөмж, 5 сэрэмжлүүлэг, 2 уриалга, 3 нэвтрүүлгийг иргэд олон нийтэд хүргэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа нь хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

Тайлант жилд дээд шатны төсвийн захирагчдын зүгээс дотоод аудитыг хэрэгжүүлээгүй байна. Харин 2020 онд Хөвсгөл аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хийгдсэн хяналт шалгалтаар тавигдсан актны биелэлтийг хангаж ажиллажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 600.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 12.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан загвараар бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11.3 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар нэмэгджээ.

Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/сая. төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	12.4	1.8	-10.6
Бараа материал	40.3	40.8	0.5
Үндсэн хөрөнгө	2299.1	2320.5	21.4
Нийт хөрөнгө	2351.8	2363.1	11.3
Өр төлбөр	8.9	6.2	-2.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2342.9	2356.9	14.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2351.8	2363.1	11.3

Авлага дансны үлдэгдэлд илүү олгосон 1.8 сая төгрөгийн олон жил болсон эзэн холбогдогч тодорхойгүй авлага тусгагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлтөд дараах ажил гүйлгээ нөлөөлсөн байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжсэн Боловсрол, соёлыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/97 дугаар тушаалаар зөөврийн компьютер, өнгөт принтерийг орлогод авсан.
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 51.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж орлогод авсан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг үндэслэн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/166 дугаар тушаалаар ашиглалтын шаардлага хангахгүй, хуучирч муудсан 7.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан.
- Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолыг үндэслэн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/167 дугаар тушаалаар элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, үлдэгдэл өртөг нь "0" болсон цаашид ашиглах 72 нэр төрлийн 59.2 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийг ашиглалтын хугацааг сунгаж, өртгийг шинэчлэн тогтоож, 26.9 сая төгрөгөөр үнэлж орлогод бүртгэсэн зэрэг болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1356.9 сая төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9.2	0	-9.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4.8	82.3	77.5
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	459.3	448.0	-11.3
Нэмэлт санхүүжилтийн орлого	87.2	90.5	3.3
Үйл ажиллагааны орлогын дүн	560.5	620.8	60.3
Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	235.8	162.9	-72.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	151.9	153.5	1.6
Хангамж, бараа материалын зардал	11.3	9.4	-1.9
Нормативт зардал	3.1	4.9	1.8
Эд хогшил, урсгал засварын зардал	3.0	3.3	0.3
Томилолт, зочны зардал	0.1	1.4	1.33
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81.4	199.2	117.8
Бараа үйлчилгээний бусад зардал	63.4	62.2	-1.2
Урсгал шилжүүлэг	50.8	8.2	-42.6
Үйл ажиллагааны зардлын дүн	600.8	605.0	4.2
Үйл ажиллагааны бус үр дүн	0.0	-1.7	-1.7
Нийт үр дүн	-40.3	14.1	54.4

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг 620.8 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 10.8 хувь буюу 60.3 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээж авсан орлогын дүн 77.5 сая төгрөгөөр нэмэгдэж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн дүн 11.3 сая төгрөгөөр буурсан, төсөвт байгууллагын өөрийн орлого 9.2 сая төгрөгөөр буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 3.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Харин үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын дүн 605.0 сая төгрөг, үйл ажиллагааны бус үр дүнг 1.7 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад нийт үр дүн 54.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь цалин хөлс, шимтгэлийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, урсгал шилжүүлэг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2021 оны төсвийн төслийг Хөвсгөл аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт тус тус хүргүүлсэн байна.

2021 оны төсвийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвтэй холбоотой зардлыг оруулан 787.8 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн байх бөгөөд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолоор 441.7 сая төгрөгөөр батлан, 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 01 тоот тогтоолоор тодотгож, 1.9 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны төсөвт аймгийн Засаг даргын шийдвэрээр 2 удаа зохицуулалт хийсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/281 дүгээр захирамжаар зардлын бүлэг хооронд 2.0 сая төгрөгийн зохицуулалт хийсэн бол 2021 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн А/608 дугаар захирамжаар зардлын бүлэг хооронд 4.2 сая төгрөгийн зохицуулалт хийснээс гадна дутуу батлагдсан түлш халаалтын зардлыг 8.1 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр нийт зардлын дүн 448.0 сая төгрөг болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 441.0 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 448.0 сая төгрөгтэй харьцуулахад 98.4 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 7.0 сая төгрөгийг Төсвийн тухай хуулийн 7.7 заалтад заасны дагуу төвлөрүүлсэн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 4.7 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь төсвийн нийт зардал 7.0 сая төгрөгөөр хэмнэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	72207	Хүүхдийн хөгжил, хамгаалал	448.0	441.0	7.0	98.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	176.7	174.5	2.2	98.8
1.2	80109	Тусгай шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал	151.5	151.5	0.0	100.0
1.3	80221	Гэрээт ажиллагсдын зардал	28.5	24.8	3.8	86.8
1.4	80233	Хүүхэд хамгаалал	49.0	48.1	0.9	98.2
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1.3	1.2	0.1	92.3
1.6	81845	Хүүхэд хөгжлийн хөтөлбөр	41.0	41.0	0.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2021 оны төсвийн жилд нэмэлт төсвийн дансаар 101.0 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна. Үүнд:

- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх “Нэг цэгийн үйлчилгээ”-ний төвийн зардалд орон нутгийн төсвөөс аймгийн ИТХ-аас баталсан 60.0 сая төгрөг
- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны А/72 дугаар тушаалаар хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг 5.0 сая төгрөг, А/49 дүгээр тушаалаар Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжихэд 2.1 сая төгрөг, А/30 дугаар тушаалаар хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс иргэдийг урьдчилан сэргийлэх чиглэлээрх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлэхэд 11.6 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны А/43 дугаар захирамжаар 2020 оны жилийн эцэст аймгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар тусгасан 10.6 сая төгрөг
- Дэлхийн зөн олон улсын байгууллагын Хөвсгөл орон нутгийн хөтөлбөрийн ажлын ерөөний түрээс болон заал ашиглуулсны түрээсийн орлого гэх мэт төсөвт байгууллагын өөрийн орлого 11.8 сая төгрөг

Дээд шатны төсөв захирагчдаас олгосон дээрх мөнгөн хөрөнгийг зарцуулах талаар Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга тухай бүрт нь тушаал гаргаж, зориулалтын дагуу зарцуулсан байна

Өөрийн үйл ажиллагааны орлогоос 10.8 сая төгрөгийг Санхүүгийн хяналт, аудитын албанаас тавьсан актын төлбөрийг барагдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад короновирусийн нөхцөл байдлын улмаас гэр бүл, хүүхэд хамгаалал, эцэг эх, багш, сурагчдад чиглэсэн олон талт арга хэмжээг “Нэг цэгийн үйлчилгээний төв”, “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв”, “Залуучуудын хөгжлийн төв”, “Хамтарсан баг”, “Хүүхдийн дуудлагын утас-108”, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, боловсролын байгууллага, аймаг, сумын захиргааны байгууллагатай

зайлшгүй хамтран хэрэгжүүлэхэд төсвийг зарцуулсан ба жилийн эцэст хэмнэгдсэн 7.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад нийт 867.5 сая төгрөгийн 87 мэдээлэл байршуулахаас 16.7 сая төгрөгийн 3 мэдээлэл байршуулаагүй, 70.9 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрсэн. Иймд дээрх зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар зөвлөмжийг хүргүүлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус газар нь 2021 онд 7.0 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргасан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах” заалтын хэрэгжилтийг хангаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны хууль, тогтоомжийн хэрэгжилтэд анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын төсөвт зардлын дүнд 10-аас доош хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 831.0 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийн хэрэгжилт 80.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	831.0	3	752.1	-	78.9	80.0
Нийт дүн	3	831.0	3	752.1	-	78.9	80.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14.3 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 5.0 сая төгрөгийн 4 алдааг залруулж, санхүүгийн тайлагнал, өр, авлага барагдуулах, төсвийн зохицуулалт, шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой 3 асуудалд зөвлөмж хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой 5.0 сая төгрөгийн 4 алдааг залруулсан. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн шалгуур хангаагүй 2.5 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан.
2. Ангилал буруу бүртгэсэн 0.8 сая төгрөгийн бараа материалыг залруулсан.
3. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлуудыг алдаатай тайлагнасан байсныг залруулж, нийтдээ 1.7 сая төгрөгөөр үр дүнг залруулсан.
4. Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн талаарх танилцуулга бэлтгэж хавсаргаагүй байсныг аудитын явцад нэмж оруулав.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зохицуулалттай холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Төсвийн зохицуулалт хийлгэхдээ Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.1 заалтад заасан “Төсвийн тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасан төсвийн зарчим болон 42 дугаар зүйлд заасныг тус тус баримтлах;” гэснийг баримтлаагүй, шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлсэн нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ыг баримталж ажиллах

2. Өр, авлагатай холбоотой асуудал

- 2.1 Илрүүлэлт: Тус байгууллагын дансанд он дамжсан эзэн холбогдогчгүй 1.8 сая төгрөгийн авлага, 2020 онд үүссэн 6.2 сая төгрөгийн халаалтын өглөг бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

- 2.1 Өгсөн зөвлөмж: Он дамжсан авлага, өр төлбөрийг барагдуулах

3. Шилэн дансны үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилэн дансны цахим мэдээллийн системд 16.7 сая төгрөгийн 3 мэдээлэл байршуулаагүй, 70.9 сая төгрөгийн 8 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заалтад “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн ил тод байдал, “эрх ба үүрэг”, “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын бүрэн хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Хөвсгөл аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	7	14.3	4	5.0	-	-	-	-	3	9.3
Дүн		7	14.3	4	5.0	-	-	-	-	3	9.3
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		1	10.9					1	10.9		
Дүн		1	10.9					1	10.9		
Нийт дүн		8	25.2	4	5.0	-	-	1	10.9	3	9.3